

БАТЛАВ: "ИКОН" ХХК

Ерөнхий захирал  Д.Аюурзана /

2018 оны 03 сар 15 өдөр



БАТЛАВ: Халдварт өвчин судлалын
Үндэсний төв

Ерөнхий захирал  / Д.Нямхүү/

№ 09



УЛААНБААТАР

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

"Икон" ХХК (цаашид "Нийлүүлэгч тал" гэх), Халдварт өвчин судлалын Үндэсний төв (цаашид "Захиалагч тал" гэх) нь хамтдаа (цаашид "Талууд" гэх) дулааны тоолуур худалдах, худалдан авах үйл ажиллагааг харилцан ашигтай, хамтран зохицуулахаар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монгол Улсын иргэний болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу захиалагч болон нийлүүлэгч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, эрх, үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудал Монгол улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Захиалагч нь нийлүүлэгчийн барааны чанарын асуудлаар санал тавих эрхтэй.
- 2.2 Барааг нийлүүлэх явцад гарсан гологдлыг арилгуулах талаар санал гомдол гаргах эрхтэй.
- 2.3 Захиалагч гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлээгүй бол Нийлүүлэгч тал учирсан бодит хохирлоо нэхэмжлэн гаргуулах эрхтэй.
- 2.4 Бараанд худалдан борлуулснаас 1 жилийн дотор үйлдвэрлэгчээс шалтгаалсан гэмтэл (хэрэглэгчийн ашиглалтаас үүдэн бус гэмтэл) гарсан тохиолдолд нийлүүлэгчийн зардлаар засварлаж өгнө.
- 2.5 Захиалагч тал гэрээний үлдэгдэл төлбөрийг төлөхгүй 7.2-т заасан өдрөөс хойш 3 сар өнгөрвөл нийлүүлэгч тал бараа бүтээгдэхүүнээ элэгдэл хорогдлыг тооцсон суутгал хийж буцаан авах эрхтэй.

ГУРАВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Нийлүүлэгч тал нь гэрээнд заасан хуваарийн дагуу барааны чанар, бусад үзүүлэлтийн шаардлага хангасан хэмжээнд нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2 Бараа нь EN1434 стандартын шаардлагыг хангасан байна.
- 3.3 Нийлүүлэгч тал гэрээнд заасан хугацаандаа барааг нийлүүлэх боломжгүй болсон бол 14 хоногийн өмнө бичгээр Захиалагч талд мэдэгдэх үүрэгтэй.
- 3.4 Барааны төлбөр тооцоог хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.

ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 4.1 Энэхүү гэрээний дагуу аль нэг тал нь гэрээгээр хүлэсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлэхэд саад учруулах, ямар нэг нөхцөл бүрэлдэх, тухайлбал гал усны аюул, дайн дажин болох, хорио цээр тогтоох, хориглолт бүслэлт хийх, экспорт, импортыг ерөнхийд нь хориглосон шийдвэр гаргах, засгийн газрын шийдвэр өөрчлөгдөх зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах бусад хүчин зүйл бий болбол гэрээгээр хүлэсэн үүргийг биелүүлэх хугацаа эдгээр хүчин зүйл үргэлжлэх хугацаагаар хойшилно.
- 4.2 Дээрх хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нь учирсан хүчин зүйлийн эхлэл төгсгөлийг нөгөө талдаа тухай бүр албан бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ГЭРЭЭГ ДҮГНЭХ ЦУЦЛАХ

- 5.1 Нийлүүлэгч тал бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг хэтрүүлдбэл гэрээний үнийн дүнгээс хоног тутамд 0.02%-тай тэнцэх алданги тооцож хохирлыг барагдуулах бөгөөд нийт алдангийн хэмжээ нь нийлүүлэгдээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 5.2 Захиалагч тал бараа бүтээгдэхүүний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд гэрээний үнийн дүнгээс хоног тутамд 2%-тай тэнцэх алданги тооцож гэрээний үнийн дүн дээр нэмж төлнө.

ЗУРГАА. НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА БА АЧИЛТ

- 6.1 Нийлүүлэгч доор заасан үзүүлэлт бүхий “Камstrup фирмийн Дулааны тоолуур”-г Захиалагч талд нийлүүлнэ.

№	Төрөл	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/ НӨАТ-тай	Нийт үнэ /төг/
1	Дулааны тоолуур Multical 602	DN100 qr-60 м3/ц	1 иж бүрдэл	5 300 000	5 300 000
2					
	Бүгд үнэ				5 300 000

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

- 7.1 Захиалагч тал дулааны тоолуурын төлбөр болох 5 300 000 төгрөгийг нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэний дараа 1 хоногийн дараа бараа бүтээгдэхүүнийг захиалагчид хүлээлгэн өгч суурилуулна.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Энэхүү гэрээ нь талууд харилцан тохиролцож гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж, 7.1-д заасан хугацаанд төлбөр тооцоо Нийлүүлэгч талын дансанд орсноор хүчин төгөлдөр болно.
- 8.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлж ажиллах ба аливаа асуудлыг харилцан зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ.
- 8.3 Энэхүү Үндсэн гэрээг баталгаажуулж эх хувийг нь 2 хувь үйлдэх бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй.

Нийлүүлэгч тал:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-54
 Пийс Тауэр 15 давхар 1503 тоот
 Компаний нэр: “ИКОН” ХХК
 Утас: 91992112, 88091346
 Факс: 70111220
 Захиалагчийн банк: Төрийн банк
 Дансны дугаар: 240000932307 /төгрөг/

Төлөөлөгч: Меженер
 Э.Болорцэцэг

Захиалагч тал:

Хаяг: УБ, БЗД, 14-р хороо, ХӨСҮТөвийн байр.
 Байгууллагын нэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв
 Утас: 99336705

Төлөөлөгч: Хангамж үйлчилгээ, инженер технологийн
 албаны дарга
 П.Элбэгбаяр
 Хяналтын инженер
 Ж.Наранцэцэг



УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

16030 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Ф.Энгельсийн гудамж, Утас/Факс: (976-11) 34 23 97,
E-mail: dhs@ubds.energy.mn

2018.01.31 № 16/147
танай 2018.01.23-ны № 5/104 -г

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Д.НЯМХҮҮ ТАНАА

Танай эмнэлэгийн барилгад DN100 диаметрийн 60.0м³/h хэмжих хязгаартай, Мультикал 66 маягийн 5219564 дугаартай "УБДС" ХКомпаний өмчлөлийн дулааны энергийн тоолуурыг 2008 онд суурилуулж хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцуулан хүлээлгэн өгсөн байдаг.

Манай компаний хэмжүүрийн ажилтан Дулааны тоолуурт шалгалт хийж, тоолуур гэмтэлтэй байгааг илрүүлэн, гэмтэл зөрчлийн акт бичсэн ба Стандарт хэмжил зүйн газрын улсын шалгагчаас төлбөр тооцооны хэрэгслэлээр ашиглах боломжгүй тухай 002487 тоот мэдэгдэл олгосон байна.

Стандартчилал хэмжил зүйн газрын 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/320 тоот тушаалаар "MULTICAL 66 C. D. E загварын дулааны тоолуурыг гадны нөлөөлөлгүй, баталгаажуулалтын лац тэмдэг хөндөгдөөгүй боловч ээлжит баталгаажуулалтанд амрагдсаны дараа 2 жилийн дотор батарей сууж дэлгэц харанхуйлан мэдээлэл боломжгүй, улмаар MNS OIMLR75-1: 2007 Монгол улсын стандартын 6.5.3 дахь заалт, техникийн болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон бол түүнд мэдэгдэл олгон, өөр загварын улсын баталгаатай дулааны тоолуураар солих замаар ашиглалтаас хассугай" гэж заасан байдаг.

Тоолуур гэмтэлтэйг тогтоосон нөхцөлд Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 8.46 дахь заалтанд "Дулааны эрчим хүч хэрэглэгчийн тоолуур гэмтэлтэй тохиолдолд төлбөр тооцоог зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн задгайгаар хийнэ" гэсний дагуу тооцоох шаардлагатай тул анхааралдаа авна уу.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б.БАТБАЯР

2/05.18
2/05.18
2/05.18
Imms